

С. Молор-Эрдэнэ

Ар Монголд  
“орчин үе”  
үгүүлэгдэнэ

---

Философийн шүүмж

## Өмнөх үг

Азийн философичидийн ээлжит хурал Японы Фукуока хотод 2011 он 4 сарын 13-наас 15-ны хооронд хийгдэхээр төлөвлөгдсөн боловч Япон орон байгалийн гамшигт өртөж хямралд орсон тул хуралыг намар хийхээр хойшлуулсан. Энэ хуралд би 2 ширхэг илтгэл бэлтгэсэн. Намар хурал хийгдэхээр болсон тул тэр үед очиж нэгэнт бэлтгэсэн илтгэлүүдээ тавихаар төлөвлөсөн хэвээрээ.

Германы философич Хэгэлийн<sup>1</sup> хэлсэн “Философич хүн тухайн цаг үеэ бодолдоо нэгтгэх хэрэгтэй” гэсэнийг баримтлан дээрх философичидын хуралд Монгол хүмүүсийн иргэншлийн болон нийгэмийн асуудалуудыг философичийн нүдээр хэрхэн харж буйгаа онолын түвшинд анализ хийж ямар гаргалгаа хийснээ илтгэл болгон бэлдсэн.

Философичидийн хурал хойшлогдсон хэдий ч нэгэнт бэлдчихсэн бодол цааш үргэлжилж дараа дараагийн бодолууд дагтаршсан тул түүнийгээ ном болгож бүр өргөжүүлж бичихээр шийдэж энэ номоо эхэлсэн. Диалэктик материализм гэж юу вэ? Яагаад диалэктик материализм ирсэн үгүй вэ? Ерөөсөө түүхэн материализм ирсэн үү? гэсэн үгүүлсэн асуултуудад хариу өгөхийг энэ номоороо зорисон.

Хоцрогдолуудаа ардаа орхиж шинийг хүлээн авч шинэчлэгдэхийг “орчин үе” гэж нэрлэсэн. Номын эхэнд хэрхэн орчин үеийн болцгоох вэ гэсэн соён гэгээрэлийн асуултыг дэвшүүлэн тависан. Дэлхийн моод Монголоор дуусдаг гэж хувцас эд хогшилийн моодийг хэлдэг гэтэл жинхэнэ “модэрн” яагаад ирсэн үгүй вэ? Үүний шалтгаан юу вэ?

Модэрн бодол, мэдлэг боловсрол яагаад ирсэн үгүйгийн шалтгаануудыг хайж түүнд хариулт өгөх зорилготой энэ номын сэдвүүдийг сонгосон. Мэдлэг, урлаг болон нийгэм гэсэн гурван чухал сэдвүүдийг хэзээнээс хамтруулан бичих гэж хүссэн хүсэл энэ номоор биеллээ. Номыг дэмжсэн хүмүүст талархалаа.

Др. Инж. Др. Фило. С. Молор-Эрдэнэ

---

<sup>1</sup> Hegel

Анхааруулга:

Тэкстийн гадаад эстетикийг эрхэмлэж бас үгийн утгыг болон өгүүлбэрийн илэрхийлэлийг тодотгохын тулд дараах дүрэмүүдийг энэ номонд хэрэгжүүлсэн.

- “Ь”, “ъ” тэмдэгүүдээс татгалзсан. Энэ тэмдэгүүдийг “и” болон “э” үсэгүүдээр орлуулсан.
- Нэр үгийн “эгшигийг” гэж бичихээс боломжоороо татгалзсан.
- “үгүй” гэсэн бие даасан үгийг хэрэглэж үгийн араас залгаж бичихээс татгалзсан.
- Латиний “е” үсгийг боломжоороо “э” үсэгээр орлуулсан.

# Гарчиг

Өмнөх үг.....	2
Эхлэл .....	6
Моод.....	9
Модэрн.....	10
Постмодэрн .....	11
Классик .....	11
Критик.....	12
Ар Монголын асуудал .....	14
1. Республикийг тодорхойлох .....	17
2. Соёлыг шинэчлэх .....	20
3. Үндсэн хуулийн төр.....	22
Иргэний нийгэм биш .....	<b>Error! Bookmark not defined.</b>
1. Социализмаас үлдсэн Ар Монгол.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Глобалчилалаас локалчилал руу.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Социолог гэж юу вэ?.....	<b>Error! Bookmark not defined.</b>
Моралийн дутагдал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
1. Төвд орон Ар Монголоос суралцах уу? .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2. Хойд Солонгосууд Ар Монголоос суралцах уу? .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Өвөр Монгол, Ар Монгол ба Буриад Монгол .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Далд ухамсар биш .....	<b>Error! Bookmark not defined.</b>

1. Бөөгийн далдлагдсан ухаан.....**Error! Bookmark not defined.**

2. Арга билэгээс мэдлэг рүү.....**Error! Bookmark not defined.**

3. Ухамсартай боловсрол.....**Error! Bookmark not defined.**

Хүйсүүдийн ялгаа .....**Error! Bookmark not defined.**

1. Эм хүйс.....**Error! Bookmark not defined.**

2. Ээжийн хүү .....**Error! Bookmark not defined.**

3. Эр эмийн ёс.....**Error! Bookmark not defined.**

Соён гэгээрэлийн хэрэгцээ.....**Error! Bookmark not defined.**

1. Иргэншил ба үүрэг.....**Error! Bookmark not defined.**

2. Урлаг ба сургамж .....**Error! Bookmark not defined.**

3. Ар Монгол хүн ба дээд Би.....**Error! Bookmark not defined.**

Нэн шинэ түүхийн боломж .....**Error! Bookmark not defined.**

1. Түүхийн төгсгөл .....**Error! Bookmark not defined.**

2. Түүхийн ашигтай ба ашиг үгүй .....**Error! Bookmark not defined.**

3. Түүхэн материализм.....**Error! Bookmark not defined.**

Төгсгөлийн үг .....**Error! Bookmark not defined.**

# ЭХЛЭЛ

Улаанбаатар хот байгуулагдсанаас хойш 70 гаруй жилд энэ нутаг дэвсгэр дээр оршицгоож буй Монгол гаралтай хүмүүс юу эсийг үзэв. Хуучин ба шинэ, хоцрогдол ба дэвшил гэх мэт зөрчилүүдийн дүнд зөрчил гарч энэ зөрчил өөрчлөлтийг шаарддаг. Өөрчлөлт өөрөө дэвшил болох ёстой. Үүнийг диалэктик гэдэг. Энэ диалэктикийн материализм ирсэн үгүй. Тэгвэл түүхэн материализм ирсэн үү? Өнөөдөр яагаад өөрчлөлтийг шаардах үгүй харин хуучиныг санагалзаж шинээс татгалзана вэ. Энэ санаархал түүхэн материализмын эсрэг биш гэж үү. Үүнд дүн шинжилгээ хийж философийн болон мэдлэгийн дүгнэлт хийхээр энэ шүүмжээ бичив.

Энэ номын цаад зорилго олон худлаануудыг засаж залруулах зорилготой. Жишээлбэл эсрэг тэсрэгийн хуули гэж хаа ч байх үгүй, далд ухамсар гэж хаа ч байх үгүй, арга билэг гэж хаа ч байх үгүй. Диалэктик эсрэг тэсрэг биш харин зөрчил. Зөрчил заавал эсрэг тэсрэг байх алба үгүй. Далд ухамсар биш харин ухаарал үгүйгээр үйлдэх. Ухаан үгүйгээр буюу ухаарах үгүйгээр үйлдэх заримдаа ашигтай заримдаа бас аюултай. Арга билэг биш харин бие ба оюун.

Хүн ерөөсөө бие болон түүний тархинд буй оюун хоёроос бүрдэнэ. Энэ хоёр хоорондоо хэрхэн хамааралтай тухай яривал үнэнд ойртох бөгөөд философийн мэргэжлийн салбарын ойлголтуудтай дөхөж очно. Энэ яриж буй сэдэвүүд бүгд хоосон биш, харицангуй биш мөн хийсвэр биш. Харин бодит, хоорондоо, хамаатай мөн барицтай. Хорвоо хоосон биш, сайн муу харицангуй биш, философи хийсвэр биш, мэдлэг тогтмол биш.

Барууны оронсуудын хүмүүсийн хувцасыг өмсөх, дуулдаг дууг дууриаж монгол хэл дээр дуулах, жийп машинуудыг унаж давхих, интэрнэт рүү орох, компютер худалдаж авах гэх мэтчилэн материаллаг зүйлсийг хэрэглэж буйгаа орчин үеийн гэж нэрлэх дутагдалтай. Орчин үеийн бодол, орчин үеийн мэдлэг, орчин үеийн сэтгэл болон орчин үеийн биеэ авч явах хүмүүжил үгүйгээр зөвхөн гаднах дүр төрхийг дууриах ердөө л гадаад үзэмжийн хойноос хөөцөлдсөн хоосон дүр. Тиймээс алдаатай бөгөөд эндүүрэл.

Ар Монгол 70 гаруй жилийн жижигхэн түүхтэй. Гэхдээ жижиг ч гэсэн чанартай. Ар Монгол нэг хэсэг Зүүн Европын оронсуудтай найз явлаа. Зөвхөн дууриаж хувцаслах биш тэдний мэдлэг боловсрол болон мэргэжил үнэмлэхийг бас өөртөө шингээж авцгаасан. 90-ээд оноос хойш цаг өөр болж хуучины хоцрогдолууд цэцэглэсэн. Өнөөдөр Төвд ороны хүмүүс л дүүрч, орогнол хайсан гадныхан бүгж, олз ашиг хайсан есөн жорын ямар улсаас ирсэн болох үл мэдэгдэх дүүрүүд л Ар Монгол ороноор орж гарах шивдээ.

Ар Монголыг хямдхан, хүсэл эрмэлзэл үгүй бас хүч тэнхээ үгүй болгох мэт. Хэн ийм болгохыг хүснэ вэ. Хэний зорилго биелэв. Хэн энэ бүгдийг биелүүлэв. Хаа л бол Ар Монгол хүн Ар Монгол орондоо бусдын дор. Ар Монгол хүн Ар Монгол оронхоо эзэн яагаад биш вэ. Нөгөө эзэгнэнхэн төрсөн Монгол хүн яагаад дарлагданхан төрсөн болчихов. Энэ асуултууд хариугаа хүлээнэ. Үүнд хариу өгөх хугацаа хэдийний болчихжээ. Энэ номоор хариулахыг хичээлээ.

Ар Монгол социализмыг л муулж чадвал бидний хэрэг бүтнэ гэж Оросуудыг л хөөж тууж чадвал бидний зорилго бүтнэ гэсэн дэндүү болхи дэндүү арчаа үгүй улстөр дээр тогтож ирлээ. Ар Монголыг ирээдүйн сайн сайхан луу авч явах ямар ч хүсэл үгүй бас хүн ардынхаа төлөө ямар ч төлөвлөгөө үгүй тийм л харанхуйгаар зөвхөн л улстөр гэсэн үгийг хэрэглэсэн бэрдүүд гаарчээ. “Орчин үе”-ийг ирүүлэх ямар ч боломжыг үгүйтүүлж хоцрогдол мухар сүсэгийг зарлан дуудсан тэр цагийн төгсгөл ирэх ёстой. Үүнд л энэ номыг зориулсан.

Ар Монгол хөгжих үгүй бүдүүлэг байцгаах хэнд ашигтай вэ? Хэн Ар Монголыг гоёж гоодоод сайн сайхан явцгаах гэхээр зориуд түүхэн роман бичиж өөрийнхөө санаагаар далайлгаж хоосон хийрхэл рүү түлхэж үүрдийн хүлцдэг болгох гэж тархи угаана вэ?

Шашин шүтлэгийн орчин үе, мэдлэгийн орчин үе, бодлын орчин үе, сэтгэлийн орчин үе, мэдрэмжийн орчин үе хэзээ ирэх вэ? Хэн авчирах вэ? Хэл бичгийн орчин үе, түүхийн орчин үе яагаад хийгдэх үгүй удна вэ? Төрийн орчин үе, улс төрийн орчин үе, үндсэн хуулийн орчин үе, моралийн орчин үе яагаад ирэх үгүй хүлээлгэнэ вэ? Эдгээрийн шалтгаан болон шалтагуудын эрэлд гарцгаая.

Бүхий л мэдлэгийн эх үүсвэр рационал танин мэдэхүй дээр явагддаг үүний зэрэгцээгээр улс төрийн, ёс суртахууны болон шүүхийн үйлдэлүүд хүний ухамсараар явагдах ёстой. Энэ бол дэлхийн олон улсын зарчим. Нийгмийн шинэчлэл гэдэг “орчин үе”-ийн дүр зураг. Хоцрогдол бүр устаж орчин үеэр солигдох учиртай.

Урлаг, яруу найраг, уран зураг, драмын театр, дуурийн театр хаа л бол орчин үе үгүйлэгдэнэ. Их дээд сургуулиудын ажихад тэнд орчин үеийн мэдлэг үгүйлэгдэнэ. Хуучины зан заншилаар эсвэл уламжлалт ёс гэж уучилж цайлгасаар сүүлдээ мухар сүсэг шашины номлолд автагдан орчин үеийг алджээ.

Өнөөдөр яагаад Шинжлэх ухааны академи болон Их сургуулиуд танин мэдэхүйн орчин үеийг ярих үгүй бас орчин үеийн номууд хэвлүүлэх үгүй хойш сууна вэ? Дэлхийн шилдэг университэтүүдэд суралцсан хүмүүс хаачив? Яагаад улс төрчид орчин үеийн талаар төсөөлөл ч үгүй явна вэ?

Үнэхээр өнөөдөр Ар Монголд орчин үеийг авчирч шинэ нийгмийг байгуулах боломж бий юу? Сүүлийн 20 жилд хөрөнгө мөнгө, наймаа панз, эртний тэмээн жинг орлосон контэйнэрийн бизнэс л төрийн зорилго болж мэдлэг боловсролыг уландаа гишгэлээ.



Мэдлэг үгүй бас боловсрол үгүй гэдэг гутамшиг. Хоосон, үхмэл бас худлаа дипломууд гэмт хэрэг.

Философийн мэргэжилийн зорилго нэгд бодож сурах хоёрт баттай аргументаар бодлоо зөвтгөж чадах. Гэтэл энэ чухал философийн мэргэжил яагаад ирсэн үгүй вэ? Хэн философийг ирүүлсэн үгүй вэ? Зарим хүмүүс философийг эзотерик гэнэ, тэр ч бүү хэл арга билэг нэрийн дор лэкц уншиж будлиулна, шашины нөхдүүд гүн ухаан гэж философийг доромжилно, багш гэх хүмүүс философийг хийсвэр гэж буруутуулна.

Философи бишрэл биш, шүтлэг биш, суу билэг биш, үлгэр домог биш. Философи гэдэг мэдэх гэсэн эрмэлзэл. Мэдэхийн тулд бодох гэдэг багажийг дээд хэмжээнд хэрэглэнэ. Хэрхэн ухамсартайгаар бодох вэ? Ингэж ухамсартайгаар боддог хүмүүс өнөөдөр дэлхийн университетүүдэд философийн мэргэжил эзэмшиж диплом хүртдэг. Бодох гэдэг зарчимтай бас дүрэмтэй болохоос толгойд хэрэгтэй болон хэрэг үгүй зүйлс эргэлдэх биш.

“Орчин үе” гэдгээр энэ номонд хоцрогдсоноос салж шинэчлэл рүү явах явцыг нэрлэсэн. Тэгвэл орчин үеийг хэрхэн ойлгох вэ? Үүний тулд моод, модэрн, постмодэрн, классик болон критик гэсэн ойлголтуудыг хамгийн түрүүнд нягтлах хэрэгтэй. Яагаад гэвэл орчин үе гэдэг зөвхөн эд зүйлсийн шинэчлэлт биш оюуны шинэчлэлт. Энэ шинэчлэлт Ар Монголд эхлэх ёстой.

Моод гэж юу вэ? Модэрн гэж юу вэ? Моод ба модэрн хоёрын ялгаа юу вэ? Постмодэрн гэж юу вэ? Классик гэж юуг нэрлэх вэ? Критик гэж хэдий хэр өргөн ойлголт вэ? гэсэн асуултуудад хариулцгаая. Бас философоор бодоцгооё. Номын дэд гарчиг “философийн шүүмж” гэсэн нэртэй ба шүүмж гэдгээр “критик” гэсэн үгийг орлуулсан. Философийн критик гэдэг ихэвчилэн асуулт тавиад түүндээ хариулахыг хэлдэг. Тиймээс энэ ном сүүлийн жилүүдэд тависан асуултууддаа хариулахыг философийн зарчимаар хичээсэн хичээлт.

## **Моод**

Моод<sup>2</sup> гэсэн үгийн утга тухайн үедээ хэсэг хүмүүс цаг үедээ тохирсон гэдгээр янз бүрийн юмс хийж, хэрэглэж бас бүтээхийг хэлнэ. Гэхдээ моодны үргэлжлэх хугацаа тийм ч удаан биш. Яагаад гэвэл дараагийн шинэ юмсаар арчигдах тул. Харин их удаан үргэлжилж чадвал “классик” гэж нэрлэдэг. Зөвхөн хувцас, дуу хөгжим, хоол хүнс, техник, амидрах хэв маяг моодны гэж бас нэрлэгдэх биш мэдлэг, философи, физик гэх мэт мэргэжилийн салбарууд моодны гэж нэрлэгдэнэ.

Моодны гэдгээр чөлөөт хүсэл, зүй, морал, амидралын ойлголт, оюун, мэдлэг, бурхан гэх мэт салбарууд бүгд шинээр тайлбарлагдсан. Соён гэгээрэл хувисгал хийсэн. Моод

---

<sup>2</sup> Mode

монголоор дуусдаг гэж эд хогшил болон өмссөн зүүсэнийг эсвэл үсний засалтыг хэлж гадаад үзэмжийг онцгойлжээ. Гэтэл моод бүр шинэ төрх, бодол болон дүрслэлийг дэвшүүлдэг.

1900-гаас 1950-аад он хүртэл дэлхийн оюуны том хөдөлгөөн өрнөж хүний оюуны үйлдэлүүд гэгдэх бодох ба сэтгэх тухай цоо шинэ бүтээлүүд бүтээгдсэн. Физикч Эйнштэйн, психологч Фройд болон хүн судлаач Дарвин гэх мэт хүмүүс орчин үеийн мэдлэгийг бүтээж чадсан.

Социализм хэдийгээр маш бага моод авчирсан хэдий ч шинэчлэлтийг гүйцэлдүүлсэн. Мэдээж гаднаас л орж ирсэн. Гэтэл социализмаас зугатааж хаашаа ч хамаа үгүй рүү явж моод тасарчээ. Социализмаас илүү тэгээд ямар моодны мэдлэг ирэв, ямар моодны оюуны хөгжил ирэв, дэлхийн моодны урлаг яагаад ирсэн үгүй вэ, дэлхийн моодны мэдлэг яагаад ирсэн үгүй вэ, дэлхийн моодны социолог яагаад ирсэн үгүй вэ? Үүнээс шалтгаалан хүмүүсийн нийтлэг боловсрол баталгаажих болон бие хүмүүсийн хөгжил удааширсан.

## **Модэрн**

Өрнөдийн оронуудад явагдсан модэрн<sup>3</sup> маш их эрчтэй явагдсан. Европ, Хойд Америк болон Австралид явагдсан зан заншил мөн уламжлалт ёснууддаа өөрчлөлт хийсэн үйл явцыг модэрн гэж нэрлэдэг. Ерөнхийдөө 17-р зууны үеийг модэрнийн оргил үе гэдэг. Ар Монголд модэрн<sup>4</sup> ирсэн үгүй. Хоёр хөрш Орос болон Хятад оронууд сүүлд 20-р зууны эхээр модэрнийг бага сага авч чадсан.

Европын оюуны салбарын модэрн үе 15-р зуунд явагдсан. Аж үйлдвэрийн модэрн 18-р зуунд, улс төрийн модэрн 18-р зуунд, эстэтикийн болон урлаг литэратурын модэрн 19-р зуунд тус тус явагдсан. 20-р зууны дундуур модэрн эцэслэсэн гэдэг. Ар Монголд модэрн ирсэн үгүйгийн шалтгаан гэвэл хоёр хөршүүд модэрнийг бүрэн хэрэгжүүлж чадсан үгүйгийн баримт.

Модэрнийн үеийн онцлогуудыг нийгмийн бүхий л салбарт явагдсан шинэчлэл өөрчлөлтөөр тодорхойлдог. Тэдгээрийн анхдагч эх үүсвэрүүд гэвэл төрийг шашинаас тусгаарласан, аж үйлдвэржилт өрнөсөн, хөгжил дэвшил гэдэгт итгэсэн, рационалыг буюу ухамсарыг сурталчилсан, нийгмийн салбарууд жишээлбэл этик, политик, шүүх, эдийн засаг, урлаг болон литэратур бие даацгаасан.

Хэрвээ модэрн Ар Монголд ирж чадсан бол нийгэм үүсэх, хөгжих боломж 21-р зуунд өгөгдсөн. Хамгийн их үүрэгтэй төрийг модэрн болгох, шашиныг модэрн болгох бас

---

<sup>3</sup> Modern

<sup>4</sup> Модэрн гэдгийг орчин үе эсвэл өнөө үе бас заримдаа эдүүгээгийн ч гэж орчуулдаг. Энд орчин гэсэн орчуулагыг хэрэглэсэн.

боловсролыг модэрн болгох их ажилууд явагдсан үгүй. Тиймээс хоцрогдсон хэвээрээ. Шинэчлэгдсэн үгүй тул орчин үеийн гэж нэрлэх боломж үгүй.

Ар Монголд эхлээд модэрн ирэх хэрэгтэй. Түүний дараа л соён гэгээрэл ирнэ. Яагаад гэвэл модэрн болж чадсан хүмүүс л соён гэгээрүүлэгчид болцгоодог.

## **Постмодэрн**

Өрнөдийн судлаачид модэрн дуусаж түүний дараа “постмодэрн”<sup>5</sup> эхэлсэн гэж хариулдаг. Энэ ухагдахууныг “модэрний дараа” гэж ойлговол мэргэжлийн нэрлэгээтэй ойр. Постмодэрн зөвхөн л Европт явагдсан урсгал. Ар Монголд ирсэн үгүй. Хоёр хөршүүд болох Орос болон Хятад оронуудад ч ирсэн үгүй. Яагаад гэвэл хоёр хөршүүдэд модэрн дөнгөж эхэлсэн. Тиймээс дууссан үгүй. Орос болон Хятадын философичид постмодэрнэгийн бүтээлүүдийг зөвхөн л орчуулсан болохоос биш улс орондоо хэрэгжүүлж чадсан үгүй.

## **Классик**

Үргэлжийн хоцрогдох үгүй үргэлжийн өнөөгөөр маргааш ч хоцрогдох үгүй тийм бүтээлүүдийг классик<sup>6</sup> гэж нэрлэдэг. Монголоор “сонгодог” гэж орчуулан хэрэглэж буй арай л дутагдалтай. Классик гэдэг төгс, хугацаа үгүй бас үлгэр жишээч гэдгийг мэргэжлийн хүмүүс нэрлэдэг. Классикал гэж бүхэл бүтэн эринүүд болон урлаг соёлын олон салбаруудыг хамарсан маш их өргөн хүрээтэй ойлголт.

Ар Монголд классикал урлаг зах зухаасаа Оросуудаар дамжин ирсэн. Ерөөсөө хоёр хөршүүд болох Орос болон Хятадын судлаачид классикал дуу хөгжим, классикал урлаг, классикал литэратурыг маш сонирхож нэвтрүүлдэг. Ар Монголд сүүлийн үед бага сага классикал дууриудыг тавиж эхэлсэн.

Нэг дутагдалтай зүйл гэвэл Бетхофэн эсвэл Моцартын “классикал” бүтээлүүдийг морин хуур хөгжимөөр тоглож буйг хараад яагаад гэсэн асуулт дувт тавигддаг. Нэгэнт Бетхофэн хөгжимийн аяаа ноотоор бичихдээ ямар хөгжимийн зэмсэг хаана хэрэглэхийг хүртэл зааж бүтээлээ бичсэн. Гэтэл энэ “классикал” хөгжимийн зэмсэгүүдийг хэрэглэх үгүй морин хуурдах тийм ч классикал биш.

Зөвхөн урлагт биш бас философийн болон мэдлэгийн салбаруудад классикал бүтээлүүдийн тухай яридаг. Ар Монголд энэ бүтээлүүдийг унших үгүйгээр философи ярих эсвэл мэдлэгийн салбарт ажиллах тийм ч шударга биш. Тэр ч бүү хэл докторын цол

---

<sup>5</sup> Postmodern гэж модэрнийн дараа.

<sup>6</sup> Classical гэсэн үгийг классик бас классикал гэж буулгасан.

хамгаалж эсвэл профессор цолтой гэж өөрийнхөө санаагаа бас хувийн бодолоо лэки болгон унших яагаад ч мэдлэгт нийцэх үгүй.

Германы философич Хумболдт<sup>7</sup> дэлхийд анх удаагаа баталгаатай мэдлэгийг дагнасан унивэрситэтийг байгуулсан. Өнөөдөрийн Америкийн, Японы, Өмнөд Солонгосын, Хятадын мөн Европын унивэрситэтүүд бүгд Хумболдтыг хэрэгжүүлсэн классикал унивэрситэтүүд.

## Критик

Критик<sup>8</sup> гэсэн үгийг “шүүмж” гэж орчуулжээ. Хэн гэдэг хүн ингэж орчуулсан тэр өнөөдөр тодорхой биш. Критик Ар Монголд ирсэн үгүй. Хоёр хөршүүдэд 20-р зууны эхээр Критик нилээд хурц хөгжсөн. Юуг ч критиклэх үгүйгээр үнэн бас зөв гэж хүлээн авах явдал ноёлох гэдэг хөгжилийг зогсоохтой адил.

Критик гэж ялгах урлагыг хэлдэг. Критик гэдэг алдааг хэлэх, бурууг заах, баримтуудыг хүнтэй хамаатай юу эсвэл хэрэг явдалтай хамаатай юу гэдгийг ялгаж салгадаг. Критик гэдэг эсэргүүцэх биш, муулах биш бас атаархах биш. Критиклэх гэдэг шалгах гэсэн ойлголт. Критикт өртөх дур үгүй хүн тэгвэл шалгуулах дур үгүй гэсэн үг. Яагаад шалгуулах дур үгүй вэ? Юу баригдах гээд сандаргана вэ? Хуулсан баригдах гэнэ. Худлаа баригдах гэнэ. Критик гэдэг үнэнийг хайх. Үнэнийг тогтоох. Тиймээс зарим этгээд критиклүүлэхээс монголоор шүүмжлүүлэхээс айж буй. Баригдахаас зугатааж буй.

Критик гэдэг үгүйсгэх биш, хоосруулах биш, дарах биш, ухрах биш. Мэдээж Ар Монголд унивэрситэт хөгжих боломжийг критикийн дутагдал зогсоосон. Хаа ч критиклэх үгүй тул нэг үгээр хэлэхэд шүүмжлэх үгүй тул ямар ч хөгжил дэвшил явагдах үгүй. Харамсалтайгаар нийгмийн болон оюуны салбарууд хөгжсөн үгүй. “Нийгмийн шинжлэх ухаан” гэдэг алдаатай хэллэг.

Критик дотроо олон төрлийн жишээлбэл эерэг критик гэвэл хүлээн зөвшөөрөх, сөрөг критик гэвэл хоосон магтах, конструктив критик гэвэл сайжруулах зорилготой, дэструктив критик гэвэл няцаах зорилготой, өөрийн критик гэвэл өөрийгөө шалгаж хянах зорилготой. Соёлын, нийгмийн, мэдлэгийн, философийн, шашины, сэтгүүлчийн гээд маш олон критикүүд мэргэжлийн салбаруудад явагдана. Критик бол олон салбарууд болон ойлголтуудыг хамарсан хүмүүсийн мэдлэг боловсролд тустай шийдвэрлэх үүрэгтэй ухагдахуун. Эдгээр ойлголтууд Ар Монголд үгүйлэгдэнэ.

Хүн төрөлхтөний мэдлэгийн эх үүсвэр хамгийн их бодол шаардсан философийн мэргэжил Ар Монголд ирсэн үгүй. Философийн “дискус” гэж маш чухал ухагдахуун бий. Үүнийг

---

<sup>7</sup> Wilhelm von Humboldt

<sup>8</sup> Critique

харамсалтайгаар мэтгэлцээн гэж орчуулдаг. Дискус гэж ам уралдан ярих биш. Нэг нэгнийгээ давж бусдад магтагдах гэсэн шоу биш. Миний зөв гэж хувийн санаагаа бусдад тулгах биш. Зөвхөн нэг хүн бувтнаж нөгөөх сонсох биш. Дискус гэж тухайн сэдвийнхээ тухай харилцан тэгш ярилцаж бас бие биенээ сонсолцох.

Энэ номыг бичихдээ моод, модэрн, классикал болон критикийн зарчимуудыг баримтлан бичсэн. Ар Монгол ороны онцлог болон түүний үндсэн хуулиудын бүтэц, яагаад өнөөдөр иргэний нийгэм бүрэлдэж чадсан үгүй вэ, далд ухамсар гэж алдаатай ойлголт шүү, морал дутагдсаны гайнууд юу вэ, хүйсүүдийн ялгааг ойлгож жэндэрийг хэрхэн зөвөөр ойлгох тухай, соён гэгээрэл Ар Монголд яагаад ирсэн үгүй тухай мөн өнөөдөр нэн шинэ хэрхэн чухал тухай бодож боловсруулсан зүйлсээ үсэглэн буулгалаа.

Номыг бичих зайлах үгүй олон шалтгаануудыг нэг гэвэл сүүлийн үед олон хүмүүсийн асуултанд хариулах тийм улстөрийн цаг үеийг биеэрээ амссан. Олон ч ярилцлагуудыг улстөрч гэдгээр өгсөн. Мэдээж философич бас түүн дээр мэдлэгийн салбарт олон жил ажилласан болохоор ихэнхи ярилцлагуудын асуултууд үргэлж оюунлаг биш байдалд хүргэдэг. Яагаад гэвэл ухамсар үгүй асуултуудад хариулах шиг хүнд зүйл энэ хорвоо дээр үгүй. Энэ ном хариулах боломж олгосон үгүй олон асуултуудын хариулт болог.

# **Ар Монголын асуудал**

Ар Монгол хэрхэн үүсэв? Өнөөдөрийн Ар Монгол дэлхийн бүх Монголтой ямар холбоотой вэ? Ар Монголыг ойлгохын тулд түүний “Үндсэн хуулийн” үүссэн түүхээр л тайлбарлах боломжтой. Яагаад ерөөсөө өнөөгийн энэ “Монгол Улс” гэгдэх нутаг бас түүнд амидарч буй хүмүүсийг Ар Монгол шүү гэсэн нэрлэгээг орхигдуулсаныг энд товчхон буулгалаа. Өнөөгийн хоёр хөршүүдийн харилцаа ч Ар Монголд зориулсан тиймээс энэ харилцаанд бас үндсэн хуули ч мөн адил Ар Монголд зориулсан шүү гэдгийг бас тодруулах учиртай.

1642 оны “40 Монгол ба 4 Ойрдын цааз бичиг” бол нэг үгээр хэлэхэд бас л нэг үндсэн хуулийн илэрхийлэл. Үндэстэн, газар нутаг болон үндэстэний хүсэл гурав нийлж үндсэн хуулийн үндэслэл болдог. Энд хүслээ илэрхийлсэн үү гэвэл илэрхийлсэн, эзэмшсэн газар нутагтай юу нутагтай. Олон Монгол нийлэн холбоотон болохыг хүссэн үү хүссэн. Тэгэхээр энэ Монгол үндэстэн гэж тодорхойлогдох боломжтой. Гэтэл энэ нөхцөл байдал 1911 оны тунхаглалаар өөрөөр эргэсэн.

1911 онд тэр үеийн Богд хаан “Олноо өргөмжлөгдсөн ардын эрхтэй хэмжээт цаазтай улс” гэж хаант буюу монарх<sup>9</sup> гэдгийг тунхаглан зарлажээ. Энд бас л Монгол үндэстэн хүслээ илэрхийлсэн. Гэхдээ дээрх 40 Монголтой харицуулахад бүрэн бүтэн үндэстэн биш. Яагаад гэвэл 40 Монгол 4 Ойрдоос энэ Богд хааны бичигт ердөө л Ар Монгол, Өвөр Монгол, Буриад Монгол, Зүүн Гар, Бараг, Халимаг Монгол гэх мэт Монголууд нэгдсэн бололтой. Тиймээс хүн ам цөөрсөн бас газар нутаг багассан тул 1642 оны цааз бичиг хүчин үгүй болж хумигдсан. 1911 оны дараах 1924 оны үндсэн хуули гэж нэртэй бичигт бүр ч ихээр Олон Монгол хумигдсан.

1924 онд хийгдсэн “Бүгд Найрамдах Монгол Ард Улс” нэртэй үндсэн хуули гэгдэх бичиг Богд хаан үхсэн тул боломжсон. Мэдээж улстөрийн мэргэжлийн “Республик”<sup>10</sup> гэсэн үгийг “Бүгд найрамдах” гэж орчуулсан явдал дэнүү алдаатай тул их хор уршигтай орчуулга болсон. Бүгд найрамдах гэж Хятад гаралтай орчуулга болов уу. Зүгээр л “Ардуудынх” гэсэн ойлголт шүү дээ. Тиймээс “Ардуудын Монгол Орон” гэж жинхэнээрээ нэрлэгдэх ёстой. Энд нэг асуухаар зүйл гэвэл 1924 оны цааз бичигт 6 Монгол хумигдаж ердөө л Ар Монгол болон Өвөр Монгол хоёр хамрагдсан болов уу гэмээр. Магад Өвөр Монгол яг орсон уу гэсэн асуулт бас гарах болов уу.

---

<sup>9</sup> Monarchy

<sup>10</sup> Res publica

Монарх буюу хаант тогтолцоог халж Ардуудын буюу рэспублик төрийн ноёрхол эхэлж буй түүхийг илтгэсэн олон хувисгалууд дэлхий дээр явагдсан. 1924 онд үүнийг л дууриаж Ар Монгол хаант биш орон болжээ. Гэхдээ 1924 оны үндсэн хуулийг зөвхөн л Ар Монголын нутаг дээр Ар Монголчуудад зориулсан хуули гэж л ойлгох хэрэгтэй. Ерөөсөө 1924 оноос хойших бүхий л Үндсэн хуулийн өргөтгөл болон шинэтгэлүүд зөвхөн л Ар Монголын нутагт амидарцгаах Ар Монголчуудад л зориулжээ. Мэдээж Бараг, Буриад, Зүүн гар, Өвөр Монголоос олон хүмүүс Ар Монголд ирж Ар Монголын харияат болцгоосоньг мартаж болох үгүй.

1642 оны цаазат бичиг бол олон Монгол нэгдсэж үйлдсэн тул нэг ёсондоо “Монголын Нэгдсэн Улс” буюу “Хамаг Монгол Улс” гэж нэрлэгдэж болохоор ба тухайн үедээ улстөрийн энэ боломжийг ашиглаж чадсан үгүй. Ингээд Монгол гэдэг ойлголт түүхэнд үндсэн хуулийнхаа зорилгоор 3 төрлөөр дүрслэгджээ. Үүнд:

- 1642 он Хамаг Монгол “United Mongolia”
- 1911 он Хамаг Монгол буюу Богд хаант Монгол
- 1924 он Ар Монгол
- 1940 он Ар Монгол
- 1960 он Ар Монгол
- 1990 он Ар Монгол

Улстөрийн энэ дүгнэлтүүдийг түүхийн номуудад тулгуурлан хийлээ. Ар Монголд рэспубликийн хувисгал ч хийгдсэн үгүй яагаад гэвэл Богд хаан үхсэн тул төрийн хэлбэр өөрчилөгдсөн. Монгол оронд соёлын хувисгал харин социализмын жилүүдэд нэг үгээр хэлэхэд Оросууд Ар Монголыг аж үйлдвэржүүлэх үед явагдсан. Харин 90-ээд оноос аж үйлдвэрийн соёл зогсож “нүүдэлчин соёл” давамгайлсан. Тиймээс Ар Монголын хувид өнөөдөр орчин үе эсвэл соён гэгээрэл ярих тийм ч амархан биш. Нэгэнт хүн төрөлхтөний чухал эринүүд Монголд ирсэн үгүй тул ардчилал эсвэл парламент гэх ойлголтуудыг ярих бүр ч утга үгүй.

40 Монгол болон 4 Ойрд яван явсаар ганцхан Ар Монгол үлджээ. Тиймээс Ар Монголд үндэстэн эсвэл үндэс гэсэн үгнүүд хэрэглэх маргаантай асуудал. Мэдээж Ар Монголд бусад Монголчууд олноор ирж хамтран оршицгоодог. Нэг хэсэгтээ эвтэй бас нэг хэсэгтээ эв үгүй. 1642 оноос хойш Монголчууд хоорондоо бүр ч их өрсөлдөж ирсэн. Нэгтгэх том хүч гарч ирсэн үгүй харин ч бутарсан дүрвэсэн зөвхөн л амиа авч үлдэх эрхэм зорилго болжээ. Ар Монголд олон Монголчууд ирж бас явцгааж нэг ёсондоо орогнол, тэмцэл уналт бас сэргэлт гэх мэт бага болон том их л улстөр явагджээ.

Ар Монгол бол жинхэнэ хатуужилтай хүмүүсийн нутаг. Ар Монголд чадсан хүн өөр хаана ч чадна. Ар Монгол хэзээ ч нүүдэл суудалын газар биш. Монголчууд нүүдэлчин биш. Монголчууд бол “Их гарууд”. Тэднийхээр эр хүний жаргал эзэн үгүй хээр биш. Харин тэдний жаргал сүм хийд болсон болов уу.



Ар Монголд орогнохын тулд сүм хийдүүдийг ашиглажээ. Тиймээс Ар Монголд орогнох зориулалтай олон зуун сүм хийд баригдсан. Шарын шашин эсвэл Буддын шашин нэртэй орогнолын сүм хийдүүд зөвхөн хэрэгсэл болохоос зорилго биш. Сүм хийдэд орогносон хамгийн томчууд гэвэл Занабазар болон Данзангийн Равжаа. Жа лам ч гэсэн сүм хийдийг ашиглажээ. Сүм хийд өнөөдөрийн хэлээр хүүхэн наймаалцдаг янханы газар, хөрөнгө мөнгө эргэлдүүлдэг бирж бас малын бүтээгдэхүүн нийлүүлдэг чэнжүүд гэлтэй.

“Цогт тайж” кинонд лам нарыг хорчгор, чөргөр бас арчаа үгүйгээр дүрсэлдэг. Энэ бол алдаатай дүрслэл. Харин лам нар тарган зузаан булчинтай том биетэй нөхдүүд шүү гэдгийг худлаагаар дүрсэлжээ. Төвдийн лам нар бол харин чөргөр. Харин Ар Монголын лам нар өөхтэй хонины мах иднэ мал хуйтай авгай хүүхнүүдтэй. “Нүгэл Буян” киноны гол дүр лам л гэхэд маш зайны эрийн дүрийг харуулдаг.

Энэ бүлэгт төрийн даалгаваруудын тухай бичихийн тулд гурван сэдэвүүдийг авч ярилцсан. Нэгдүгээрт рэспубликийн тухай, хоёрдугаарт соёлын хувисгал хэрхэн чухал тухай, гуравдугаарт үндсэн хуулийн төр үгүйгээр юу ч бүтэх үгүй тухай сэдэвүүдийг дэлгэрүүлэн бичсэн.

## **1. Рэспубликийг тодорхойлох**

Төрийн тухай асуулт гэдэг юунд үнэнч ямар зарчим барيداг төр вэ гэсэн л асуулт. Хамгийн түрүүнд хэн үүнийг бодож түүний тухай идеологийг бичиж ард түмэнд хүргэх вэ гэсэн ариун үйлс. Төрүүд дотроо олон төрлийн жишээлбэл хаант, ардын гэх мэт. Хаант төрийг “монарх” харин ардын төрийг “рэспублик” гэж мэргэжлийн номуудад бичдэг. Ард олны сайн сайханы төлөө гэсэн уриа бол Рэспубликаас эхлэлтэй бөгөөд хааны эсрэг гэсэн илэрхийлэл. Ромын антик болон Францын хувисгал хааныг халж Рэспубликийг зарласан.

Рэпубликанизмын тухай 1945 оноос эхлэн түлхүү ярих болсон ба яагаад гэвэл либэртаризм дутагдалтайгаа харуулсан. Өнөөдөр ч либэртаризмыг сурталчилдаг Америк орон хүртэл анхны улстөрийн онол болох нэг үгээр хэлэхэд Америк ороны суурилж ирсэн Рэпубликанизмын үнэтүүдээ дахин сэргээхийг ярих боллоо. Ерөөсөө Америк орон бол Рэпубликанизмын өлгий орон. Рэпубликанизм хүн ардыг “иргэн” болгох мөн үндсэн хуулиа социалын болон моралын агуулгаар баяжуулах. Энэ л эрдэмийг Рэспублик гэсэн ойлголт илэрхийлдэг. Тиймээс төр өөрөө “иргэний төр” болох ёстой.

Монгол оронд өнөөдөр ямар төртэй гэдгийг тодорхойлох тийм ч амар биш. Яагаад гэвэл “Рэспублик” гэсэн философийн ойлголтыг “Бүгд найрамдах” гэж алдаатай орчуулсан. Зөвөөр орчуулбал “Ардын” гэсэн ойлголт. Тэгэхээр жишээлбэл Бүгд Найрамдах Монгол Ард Улс биш харин Ардын Монгол Улс гэж орчуулбал зөв. Тиймээс БНМАУ биш АМУ гэвэл таарна.

Модэрн ойлголтоор Республикийг бас ардын ноёрхол ч гэдэг. Гэхдээ Республик гэхээр шууд л демократчилагдсан ерөнхийлөгчийн тогтолцоотой гэж ойлгож болох үгүй. Дэлхий дээр хамгийн жижиг Республик гэж Науруг, хамгийн том газар нутагтай Республик гэж Оросын Фэдэрацийг харин хамгийн ахмад Республик гэдгээр Сан Мариног тэмдэглэжээ.

Төр гэж юу вэ? Түүнийг хэрхэн ойлгох вэ? Хамгийн анхны төрийн онолыг хэн бичсэн бэ?

2500 жилийн өмнө дэлхийн хамгийн анхны төрийн тухай номыг Грекийн философич Плато бичсэн. Түүний сурагч философич Аристотэл түүний дараагаар “политик” гэсэн нэртэй номоо бичсэн. Философич Аристотэлийн асуулт бол ямар төрийг тэгээд хамгийн сайн төр гэх вэ гэсэн асуулт. Төр гэдэг удирдах ба тэргүүлэх бас заах мөн зөвлөх. Энэ бүгдийг таамгаар хийх үгүй харин онолын туслалцаатайгаар хийнэ.


Дэлхийд алдартай Республикийн төлөө Хааныг эсэргүүцсэн хувисгалуудын нэг бол Орос оронд өрнөж ялалтанд хүрч дэлхийн нүүр царайг өөрчилж 20-р зууны эхэн үеийг донсолгосон “Октябрийн хувисгал”. Анх 1905 оны хувисгал нэгэнт бүтэл үгүйтсэн тул дараагийн хувисгалдаа бэлдэцгээсэн. Үүнд Ленин том үүрэг гүйцэтгэсэн. Тэр Швэйцар улсад олон жил амидарч Германы философичидийн номыг уншиж Марксын онолыг Орос оронд хэрэгжүүлэхээр шулуудсан.

Оросын Октябрийн хувисгал мөн Хятадын Соёлын хувисгал хоёр хоёулаа энэ хоёр том ороныг өөрсдийнхөө замаар орчин үеийг угтсан үйлс рүү довтлох агуу хувисгалууд болж чадсан. Ядуу буурай Орос орон аж үйлдвэржсэн. Шашины догматай Хятад орон хуучнаас салж шинэ соёл руу очсон.

Дарвины эволюцаар хүн гэдэг чинэ амитан шүү дээ гэсэн биологийн ойлголтыг анх дэвшүүлж тависан ба тиймээс хүн болохын тулд олон зүйлсийг сургаж хүмүүжүүлэх ёстой гэдэг. Ерөөсөө хуули үгүй газар бүгд л нэг нэгнийхээ эсрэг чоно болцгоодог гэсэн философич Хоббэсийн “Лэвиатан” ном ард олонд заавал гэрээ хэрэгтэй гэдгийг анхааруулсан. Энэ гэрээ бол үндсэн хуулиар баталгаажигдана.

Аливаа гэмт үйлдэлийн шалтгаан уламжлалын, социалын болон оюуны шалтгаануудтай. Тэгвэл гэмт этгээдийн шалтгаан эдийн засгийн, социалын, уламжлалын болон улстөрийн шалтгаантай. Тиймээс үүнийг зохицуулсан төр заавал хэрэгтэй.

Октябрийн хувисгалын дараа Республик болсон Орос оронд боловсрол мэдлэгтэй бас удирдах ажил хийж чадах тийм оюунлаг хүмүүсийн хэрэгцээ маш ихээр гарсан ба үүнийг хурдан хугацаанд амжилттай явуулахын тулд Коммунист намыг байгуулсан. Коммунист намаар л шинэ Орос хүн бэлтгэх ажилтангууд бэлтгэгдсэн. Ердөө 20 жилийн дотор Орос орон аж үйлдвэрийн орон болоход бэлэн болсон. Барууны оронууд үнэхээр л коммунистуудын давуу талыг харсан.



Социалист төрийн онолч В.И. Ленин<sup>11</sup>

Ленин боловсрол үгүй бас ямар ч хөгжил үгүй Орос ороныг хэрхэн богино хугацааны дотор Баруун Европын оронуудын хэмжээнд хүргэх талаар олон жил Германы философичидын номыг уншиж боловсорсон. Тэр социалист хөгжилийн замыг сонгож капитализмаас татгалзсан. Яагаад гэвэл Барууны империалистууд Орос ороныг хувааж идэхээс хамгаалахыг уритал болгосон.

Ленин ердөө л Оросын ард түмнийг аврахыг зорисон. Үүний тулд өөрсдийгөө философичид гэж нэрлэн худлаа хоосон юу ч бүтээдэг үгүй эсэргүүцэгчидийг, ард түмний төлөө ямар ч сэтгэл үгүй философич нэрийн дор мухар сүсэгдэх, онолдох, өөрсдийгөө магтуулагчидыг нийлүүлэн бүгдийг Орос ороноос Ленин хөөн гаргасан.

Ар Монголын үндсэн хуули ирээдүйд зориулсан үгүй харин өнгөрсөнийг дурссан. Төрийн ордоны өмнө монгол хүний ирээдүйн амидралыг билэг тэмдэг болгсон үгүй харин 800 жилийн өмнөх үлгэр домгийг билэг тэмдэг болгож хөшөө босгосон. Үүнээс харахад Ар Монгол ирээдүйг харах хүсэл үгүй харин өнгөрсөндөө мансуурахыг илүүчилсэн.

Төрөө шүтэх үү эсвэл хардахуу. Төрд итгэх үү эсвэл шалгах уу. Сүүлийн 20 жилд төрд ямар өөрчлөлтүүдийг авчирав?. Социализмын үндсэн хуулийг хэрхэн өөрчилөв. Хэн өөрчилөв? Ямар мэдлэгтэй хүн өөрчилөв? Хаанаас боловсрол авсан хүн үндсэн хуулийг өөрчилөв?

Гадаадын ямар төрийн нөлөөгөөр бас зөвлөлгөөгөөр улстөрчид ажиллана вэ? Эсвэл хэнээс ч зөвлөлгөө авдаг үгүй юу? Өөрсдийнхөө хар толгойгоор таамаглан төрөө удирддаг уу? Гэх мэт асуултуудыг хариулах тийм ч хялбар биш болжээ. Төрийн үйл ажиллагаа нэгэнт ард түмэнд нээлттэй биш тул өнөөдөр Ар Монголд “Республик” ярих ямар ч боломж үгүй.

---

<sup>11</sup> 1917 оны 10 сар нэртэй зурагийг Серов зуржээ.

## 2. Соёлыг шинэчлэх

Социализм жинхэнэ хөгжиж чадвал түүнийг л демократи гэж нэрлэнэ гэж Шумпэтр<sup>12</sup> номондоо бичсэн. Социализмыг жинхэнэ бүтээж чадсан үгүйгээр Зүүн Европ болон Орос оронд эхэлсэн социализмаа гүйцээх үгүйгээр төгсгөл болгосон. Хүчээр төгсгөсөн. Түүний дараа өөрчлөн байгуулалт нэрээр социализмд нэгэнт бүрэлдсэн нийгмийг бусниулсан үйл явдал өрнөсөн. Үүний хамгийн том золиос гэвэл социализмын бүтээн босголтонд гар бие оролцож явсан боловсролтой мэдлэгтэй хүмүүс.

Октябрийн хувисгалын нөлөөгөөр социалист орон болсон Хятад улс 20-р зууны эхээр соёлын хувисгалыг ихээр шаардсан. Яагаад гэвэл социализм урагшлах үгүй феодализм ноёрхсон хэвээр тул феодализмын соёлоос салахыг олон хүмүүс хүсэж хувисгал хийхийг уриалсан. Хятад орон социализмын замыг сонгосоноор дэндүү бүдүүлэг дэндүү боловсрол үгүй Хятадын ард түмнийг нойрноос сэрээсэн.

Феодализмын соёлоос сална гэдэг Мао Цэдунгийн хувид хамгийн том зорилго. Азийн хэтэрхий зан заншил уламжлал ярисан хуучиныг санаглазаж Күнз, Будда ярисан хийрхэсэн онолчид, философичид гэж өөрсдийгөө өргөмжлүүлсэн худлаа философичидийг бүгдийг Мао сургуулиудад лэцц уншихыг хорисон. Хуучинаас салж шинэчлэгдэхийг худлаа онолчидод анхааруулсан.



---

<sup>12</sup> Schumpeter

## Хятадын Соёлын хувисгалын онолч Мао Цэдунг<sup>13</sup>.

1960-аад онд Хятадад “рэвизионистууд”<sup>14</sup> ихэссэн гэж нийтэд зарласан. Рэвизионистууд дахин хянаж шалгаж буй гэдэг нэрийдлээр анхныхаа зорилгоо умартаж суурилсан онолоосоо хазайгчид. Тэд ард түмнээс тасарсан гэж Мао дүгнэсэн. Хятадын Коммунист намын дарга Мао социализмыг Хятад оронд бүрэн хэрэгжүүлэхийг зорисон. Гэхдээ нэгэнт социализм саарч буй тул үүнийг засаж залруулахын тулд жинхэнэ “идеал социализмыг” байгуулахаар Хятад орон даяар уриалсан.

Хятадын Соёлын хувисгал улстөр, соёл, олон нийтийн санал асуулга, ерөнхий боловсролын сургуулиуд болон их дээд сургуулиудыг хамарсан.

Коммунист Хятад болон социалист Зөвлөлт улсуудын хөгжил Ар Монгол оронд хүртээгдэж Ар Монгол орон ч гэсэн өөрчлөлттэй золгосон. Гэхдээ яг Монгол хүмүүст зориулсан тэдний төлөө хувисгал явагдсан үгүй. Хамгийн гол зорилго дэндүү их тархсан шарын шашиныг устгах анхны зорилго болсон.

1921 оны Ардын хувисгалын агуулга монгол хүнийг шашны догманаас салгаж бичиг үсэгт сургах. Үүний тулд Төвдөөс гаралтай өөрчлөлтийг эсэргүүцсэн хүмүүсийн орогнодог шарын шашины сүм хийдийг устгах. Тэгсэн үгүй цагт ямар ч шинэчлэл эхлэх боломж үгүй. Ардын хувисгал “устгах” хувисгал болсон. Монгол хүний мухар сүсэг болсон итгэл үнэмшилийг устгасан. Одоо шинэ шинэ итгэл үнэмшил хэрэгтэй. Энэ бол бичиг үсэг сурах мэргэжилтэй болж өөрөө өөрийгөө авч явах. Хуучин хүү шинэ хүү болох.

Шарын шашинд идэгдсэн Монгол хүний итгэл үнэмшил юунаас бүтсэн бэ гэхээр айх айдас, хоосон болон өргөл бариц. Монгол хүн сэтгэж бие дааж л болох үгүй хэрвээ сэтгэлээ илэрхийлвэл наадах чинэ хоосон эсвэл солиорчихож гэнэ. Ном уншаад гэгээрсэн монголчуудыг “номын цагаан солио” тусжээ гэнэ. Энэ итгэл үнэмшилийг шинэ орчин үеийн итгэл үнэмшилээр солих тийм ч амар гүй гэдгийг социализмын 70 жил харуулсан.

Төвдийн дэндүү догматай маш осолтой Буддизмын урсгалыг Хятад болон Япон оронууд хэзээ ч зөвшөөрч улс орондоо нэвтрүүлсэн үгүй. Тиймээс энэ оронуудын хувид ямар ч идэвхи үгүй мухар сүсэг холуур өнгөрч чадсан. Тиймээс ч энэ оронууд хөгжиж өөрчилөгдөх бүрэн боломжтой хэвээр үлдсэн. Хятад, Япон болон Өмнөд Солонгос гэх мэт оронууд Төвдийн шарын шашинаас холуур байж чадсан тул дэлхийн мэдлэгийг амархан хэрэгжүүлж өөрчлөгдөж чадсан. Харин Ар Монгол Төвдүүдийн гар хөл болсон. Тиймээс ч өнөөдөр өөрчлөлт шинэчлэлт Ар Монголд ирэх тийм ч амар биш. Дэлхийн мэдлэгээс дэндүү хоцорсон.

---

<sup>13</sup> Мао-гийн зургийг Энди Вархол \Warhol\ зуржээ.

<sup>14</sup> Revisionismus

УИХ-ын нэг гишүүн Америкийн Манхатан хотын хоёр өндөр нурж унасан 9 сарын 11-ний үйл явдалыг шууд л Улаанбаатарт 7 сарын 1-нд болсон үйл явдал адилтган яриж хоолойгоо засаж ядан ярихыг хараад их л гайхал төрсөн. Америк орон гадны довтолгоонд өртсөн гэдэг. Түүнийг тухайн үедээ дайн гэж хүртэл дэвэргэсэн. Улаанбаатарт гэвэл 5 Монгол хүнийг буудаад алчихсан. Дотоодын үйл явдал. Иймэрхүү гадаад дотоодын ялгааг ялгаж чадах үгүй глобалчилал локалчилалын ялгааг олох үгүй улстөрч явна гэдэг бас л хоцрогдсоны баримт. Хуучин соёлоо орхиж шинэ соёл руу хэзээ очих вэ?

Социализмын үед бид чинэ даалимбан өмд хувцастай л алхаж явлаа гэж нэгэн намын дарга зовлон эдэлсэн хүний дүрд тоглох. Гэтэл тэр хүн өөрөө социализмын үед барууны хос жинс өмсчихсэн явсан биш билүү. Тэр хүн улс ороныхоо мөнгөөр хилийн чандад сурахаар оччихоод хичээл хийхээс залхуураад хөөгдөөд ирсэн үгүй бил үү. Ямар хүн чанар вэ? Хуучин соёлдоо яагаад баригдана вэ? Шинийг яагаад ойлгох үгүй явна вэ?

### 3. Үндсэн хуулийн төр

Түүхийн болон улстөрийн мэргэжлийн салбаруудад “үндсэн хуулийн төр” гэдгээр төрийн нэг боломжийн хэлбэрийг нэрлэдэг. Үүний цаад утга гэвэл төрийн “засаглал” буюу “төмөр нүүрийг” үндсэн хуультай зангидахыг хэлсэн. Ингэж зангидсанаар төрийн төмөр нүүрийг хазаарлах ёстой. Нэг үгээр хэлэхэд төрийн “эрх мэдэлийг” үндсэн хуулиар хязгаарладаг. Мэдээж үүнийг Барууны “чөлөөт демократтай” бас эрхт төртэй оронуудын ойлголтоор ойлгохоос биш Ар Монголын ардчилал гэж нэрлэдэг гаж ойлголттой ямар ч хамаатай биш.

Үндсэн хуули гэж юу вэ? Үндсэн хуулийн зорилго юу вэ? Ар Монголын үндсэн хуули яагаад классик “конституц” биш вэ гэвэл хэнд зориулсан тэр үндэстэнийг үндсэн хуулийн эхэнд нэрлэсэн үгүй. Аливаа үндэстэнд зориулсан үгүй бас тэдний хүсэлийг<sup>15</sup> тодорхойлсон үгүй тул амин сүнс үгүй. Тиймээс тэнд аливаа хүсэл эрмэлзэлийг бас тунхагласан үгүй. Ерөөсөө тийм боломж ч үгүй. Яагаад гэвэл Ар Монгол дэлхийгээр тарсан хамаг Монголын нэг жижигхэн хэсэг. Үндсэн хуули өөрөө үндэстэний хуули биш.

Одоогоос 1500 гаад жилийн өмнө 533 онд дэлхий дээр Ромын хуулийн эхний хэсэг зарлагдсан. 1468 анх ном болон хэвлэгдсэж хүн ардад зориулсан хоорондын амидралыг зохицуулсан хуулийн ном<sup>16</sup> хэвлэгдсэн. Ром хотод анх хуулийн тухай хэвлэгдсэн энэ товхимолын агуулга “Институц” гэж юу вэ гэдгийг тодорхойлсон. Тухайн улс ороны институцууд л хэн хамаатан бэ, хэн хэний албан ёсны хүүхэд вэ, гэрээслэл гэж юу вэ, өмч гэж юу вэ, газар гэж юу вэ, иргэн гэж хэнийг нэрлэх вэ, нийгэм гэж юу вэ, шударга ёс гэж юуг хэлэх вэ, хуулийг юу гэж ойлгох вэ гэх мэтчилэн албан ёсны институцууд үүсэж

---

<sup>15</sup> Nation Will

<sup>16</sup> Corpus Iuris Civilis

түүнийг хариуцсан байгууллагууд байгуулагдсаны дараа л төрийн тухай асуудал ярихаас биш ямар ч бичиг баримт үгүйгээр төрийн, нийслэлийн тухай бас хотын тухай ч ярих боломж үгүй.

Тархай бутархай монголчуудыг БНМАУ нэрийн дор нэгтгэсэн. Социализм бол нэгдэл. Орон бүхний пролетар нар нэгдэгтүн. Монгол хүмүүс нэгдэгтүн. Энэ нэгдэлийн эсрэг хэн зогсоно вэ түүнд ялагдал ирнэ. Лам нарын бослогод ялагдал ирсэн яагаад гэвэл нэгдэлийн эсрэг тул шинэ амидралын эсрэг тул тэд эсэргүүнүүд.

1990 оны өөрчлөн байгуулалтын агуулга социализмыг устгах. Тиймээс энэ Монголчуудын нэгдэлийн эсрэг үйл ажиллагаа. Тэгэхээр бас л эсэргүүнүүд. Нэгдэл, хамт олон болон тэгш эрхийн эсрэг эрх чөлөө гэсэн ойлголтыг эсрэг тависан. Тиймээс 90-ээд оны өөрчлөлт тэгш эрхийн оронд эрх чөлөөг чухалчилсан.

Эрх чөлөөг уриалагчид хувичлал явуулж социализмын бүтээн босголтыг нураасан. Тиймээс өөрчлөн байгуулалт “нураах” үйлдэл. Энэ нураалт аж үйлдвэр, хөдөө аж ахуй, боловсрол, эрүүл мэнд гэх мэт улс ороны бүхий л бүтээн босгосон дэвшилтэт аж амидралыг нураасан.

Социализмаар нэгдсэн монголчуудын нэгдэлийг нураасан. Улстөр гэсэн ганцхан үг л социализмын үед бүтээн босгож чадсан “нийгмийг” нураасан. Хаа ч хамаа үгүй одоо энэ улстөр гэдэг үгийг л хэлэх хэрэгтэй. Энэ үг бүгдийг айлгана бүгдийг зогсооно бүгдийг нураана.

Социализмыг нураах зорилготой хүмүүс зөвхөн тэр онолыг л нураах чухал гэдгээ ойлгосон үгүй. Социализмыг нураах гээд бүтээн босголтыг нураасан. Энэ зөвхөн матэриаллаг бүтээн босголтыг биш бас бодол болон сэтгэлийн бүтээн босголтыг нураасан. Мэдлэг боловсролыг социализмтай холбож дэлхийд хүчинтэй мэдлэг боловсролыг социализмын нэр дор нураасан.

Хувичлал нэрийн дор явагдсан хөрөнгийн шилжүүлгэ ердөө л бодит үл хөдлөх үгүй хөрөнгүүдийг тасдаж салгаж худалдаалсан худалдаа явагдсан. Хувичлал ерөөсөө модэрн утгаараа бол тухайн үл хөдлөх хөрөнгийг хэвээр үлдээж цааш улам хөгжүүлээрэй л гэсэн эрхэм зорилготой. Гутлын үйлдвэрийг хувичлах гэдэг бол энэ үйлдвэрийг цааш улам дэвшилтэт үйлдвэр болгоорой гэсэн даалгавар. Энэ даалгаварыг хэн ч хүлээн авсан үгүй хувичлал нэрийн дор худалдааны зах үүссэн.

Хувичлал нэртэй том худалдааны зах том том феодалуудыг төрүүлсэн. Том компанууд үүссэж гэр бүл хамаатан садангуудын компанууд бол ерөөсөө феодалжсан компанууд. Капитализмын өмнөх буюу феодализмын сүүлч хэсгийн улстөр болон эдийн засгийн талбар Монгол ороныг ноёрхжээ. Үүний баталгаа гэвэл хөгжлийн “линээр”<sup>17</sup> явц гэж үгүй.

---

<sup>17</sup> Linearity үгийг шугаман гэж алдаатай орчуулдаг. Дараагийн явц өмнөхөөсөө шууд хамаарахыг нэрлэдэг

Хэрвээ л ардчилал гэсэн монгол үгээр философийн гаралтай “демократи” гэсэн ойлголтыг орчуулсан гэвэл энэ улстөрийн ойлголт Ар Монгол оронд яагаад бүтэл үгүйтсэнийг сүүлийн 20 жилийн баримтууд нотолно.

Демократи буюу ардчилал өөрөө гурван чухал үзүүлэлтүүдээс хамааралтай бөгөөд тэдгээр дараах:

1. Эрх чөлөө
2. Тэгш эрх
3. Ахан дүүсэг

Энэ гурван үзүүлэлт Ар Монгол оронд явагдах боломж тун бага. Яагаад гэвэл эдгээр Монголын уламжлалт ёс болон зан заншилтай харшилддаг. Тиймээс нэг бол дээрхи үнэт зүйлс гэж нэрлэдэг үзүүлэлтүүдийг эрхэмлэх эсвэл тэдгээрийг орхиж уламжлалт ёс руугаа буцах.

Сүүлийн 20 жилд ардчилал гэсэн Зүүн Европоос орж ирсэн улс төрийн шинэчлэл Монгол оронд улс төрийн сайжрал авчирсан үгүй. Ардчилал бүтэл үгүйтсэн. Яагаад бүтэл үгүйтсэн бэ гэвэл нэгдүгээрт эрх чөлөөг буруу тайлбарлаж буруу хэрэгжүүлсэн. Эрх чөлөө өөрөө нэг зүйлийн төлөө. Тэр зүйл өөрөө тодорхой биш.

Энд яриж буй сэдэвүүдийг нухацтайгаар бас дэлгэрүүлэн бодоход яагаад орчин үе ирэх гүй алдагдсаны гол эзэн хэн бэ гэвэл Ар Монголын үндсэн хуулийг л хэлэхээс өөр зам үгүй. Шинэ төр шинэ Монгол хүний гарц бол шинэ үндсэн хуулийг л хийх тэр ариун үйлс гэдгийг л олж харах явдал.



Уламжлалт унаа “моридууд” ба шинэ унаа “машин”.



Зурагт Монгол оронд анх удаагаа техник орж ирж буйг баримтжуулжээ. Түүхийн солигдол. Гаднаас оруулж ирсэн техник технолог. Ар Монголд яг л ингэж дэлхийн мэдлэгийн өчүүхэн хэсэг маш хурдтай орж ирсэн.

Ар Монгол олон зуун жил олон Монголын орогнолын газар болсон. Ингэж орогнолын газар болгохын тулд олон зуун сүм хийд бариж байгуулжээ. Тиймээс шашин нэртэй сайн эрүүдийн орогнолын сүм хийдүүд олон мянган малтай баян бас маш их эрх мэдлийг эзэмшсэн. Тэд авгай хүүхнүүдтэй юугаар ч дутах үгүй тансаг амидарцгаасан. “Нүгэл Буян” киноны гол дүр лам Хүрээний хамгийн том янхан хүүхэний охины эцэг бөгөөд хөдөө гарч малынхаа тоо толгойг шалгаж бизнэсээ бас урагшлуулдаг. Ёстой л сайн эр.

Яг л сүм хийдүүд орогнох газар байсантай адил өнөөдөрийн Ар Монголын парламент буюу Их Хурал бас л УИХ-ын гишүүдийн орогнолын газар мэт харагддаг. Занабазар, Равжаа мөн Жа ламтангууд өнөөдөр лав УИХ-ын гишүүн болчихсон. Яагаад УИХ сүм хийдтэй адил харагддаг вэ гэхээр гишүүн болчихвол шоронгийн хаалга татах үгүй, бизнэсээ унагаах үгүй бас залуухан хүүхнүүдээ алдах гүй найдвартай мэт.

Тиймээс УИХ-ын үйл ажиллагаа моралын зөрчилд бүр хямралд орсон. Түүнийг моралтай улстөрчид дотроо мэдэрч эхэлсэн. Түүндээ зөрчилддөг улстөрчид ч бий. Морал гэдэг юу вэ гэвэл худлаадаа бухимдах, буруугаа гэмших, дотор давчдах. Моралын зөрчил тухайн хүнийг одоо ингээд бүгдийг зогсоож дахин шинээр эхлэх үү нэг үгээр хэлэхэд одоо бүх үнэнийг дэлгэх үү гэсэн л зөрчил. Эс үгүй гэвэл нуун дарагдуулж цааш үргэлжлүүлэн үргэлжийн зөрчилдөө баригдаж зөрчилийнхөө золиос болох.

Харин морал үгүй улстөрчидийн хувид энэ бүгд явагдах үгүй тул тэдний харц хоосон бас яриа хоосон гэдэг шууд л баригддаг. Тийм хүмүүсийг танихад тун амархан. Ердөө төвөг үгүй.

Моралтай төр гэдэг Ар Монголын шунал үгүй төр гэсэн ойлголт. Мөнгө хайсан хөрөнгөжих гэсэн хүмүүс улстөрд гишгэх газар үгүй шүү гэсэн идэолог чухал. Тиймээс ёс суртахуунтай буюу этиктэй төрийг босгохыг юу юунаас чухал шүү гэдгийг ухамсарлах.

Энэ моралын асуудалыг л шийдэх үүрэгтэй гэдгээ “Үндсэн хуулийн цэц” гэдэг байгууллага өнөөдөр ч хүртэл үүргээ ухамсарласан үгүй. Хуули гэдэг нэг ёсондоо гэрээ. Энэ гэрээнд талууд нэг нэгнийхээ зөвийг баталгаажуулсан. Харин хуулиас гадна моралын болон зүйн асуудалыг хуулинд заасан үгүй тул үүнийг л үндсэн хуулийн цэц гүйцэлдүүлэх ёстой. Яагаад гэвэл Дээд шүүх хуулийн талаасаа хамгийн дээд байгууллага.

Ар Монголд одоо ирэх буй хувисгалыг хүмүүс мэдэрч буй магад үгүй зөнгөөрөө зөнлөж буй. Хувисгалын “оюун” Монголын агаарт хөвнө. Нэгэнт оюун бие үгүй тул түүнийг харах боломж үгүй. Тиймээс энэ хувисгалын оюуныг биежүүлэх хэрэгтэй. Түүнд бие өгөх хэлбэр өгөх л одоо гарах асуудал. Ямар бие өгөгдөх вэ гэвэл магад жагсагч олон нийт л гэж хэлэх болов уу. Тиймээс жагсагчид одоо оюунтай болно. Нэг үгээр хэлэхэд “хар

маасс” одоо зөвхөн бие биш бас оюунтай иж бүрэн субэкт болно. Хувисгалын субэкт л чухал яагаад гэвэл түүнд хүсэл бий. Хүсэлээ хэрэгжүүлэхийн төлөө явах шиг эрхэм зүйл энэ хорвоод үгүй.

Өнөөдөр энэ бүх аргын буюу материаллаг болон билэгийн буюу оюуны нураалтыг хэрхэн дахин босгох вэ. Социализм огт юу ч үгүйгээс цоо шинийг босгосон. Тэгвэл өнөөдөр монголчууд нураасануудыгаа дахин босгох ажил гарлаа. Энэ ажилыг хэрхэн яаж эхлүүлж цаашид амжилттай өрнүүлэх вэ. Яаж хар маасс бүтээн босгодог бие даасан монголчуудын маасс болох вэ. Үүний тулд иргэний нийгэм хэрэгтэй. Гэтэл Ар Монголд иргэний нийгэм бий билүү.

